15-24 насны залуусын согтууруулах ундааны хэрэглээ, мэдлэг, хандлагыг судалсан үр дүн

Б.Батчимэг[1], М.Ундрам[1], Ц.Энх-Оюун[2]

[1]АШУШИС, АУС, Өрхийн анагаах ухааны тэнхим
[2] АШУҮИС, НЭМС, Эпидемологи Биостатистикийн тэнхим
Цахим шуудан: Batchimegbayarsaikhan11@gmail.com, Утас: 99159717

Түлхүүр үг:
Хорт зуршил
Стандарт уулт
Эрсдэлт зан үйл
Өсвөр үе

Товч утга:
Үндэслэл: Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын (ДЭМБ) 2021 онд гаргасан тайланд дурдсанаар 2019 онд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн архины хэрэглээ хамгийн өндөр байгаа нь Европын бүс, Америкийн бүс нутаг, Номхон далайн баруун хэсэгт байсан байна. Африкийн хөндлөн огтлолын судалгаагаар Өмнөд Африкт насанд хүрэгсдэд ногдох архины хэрэглээ дэлхийн бусад бүс нутгаас хамгийн өндөр байна.Түүнчлэн архины эрсдэлтэй хэв маяг нь 15-24 наснаас эхэлж насанд хүрсэн хойноо үргэлжилдэг байна. **Зорилго:** 15-24 насныхны согтууруулах ундааны хэрэглээ, мэдлэг хандлагыг судлах. **Арга, аргачлал:** Улаанбаатар хотын болон 4 бүсийг хамруулсан ЕБС, их дээд сургууль, коллеж болон МСҮТ-ийн 1002 оюутан залуусыг санамсаргүй түүврийн аргаар сонгож тэдгээрийн согтууруулах ундааны хэрэглээ, түүнтэй холбоотой мэдлэг, хандлагыг судлах тодорхойлох зорилготой уялдуулан судалгааг сургуульд суурилсан агшингийн загвараар хийж гүйцэтгэсэн. Судалгааны ажлын үр дүнгийн статистик боловсруулалтыг IBM Statistics компанийн SPSS стастик үр дүнгийн боловсруулалтын 26.0 хувилбар дээр хийж гүйцэтгэв.Судалгааны арга аргачлалыг АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2023 оны 01 сарын 20 ны өдрийн 2023/3-01 тоот хурлаар хэлэлцүүлж судалгаа эхлэх зөвшөөрлийг авсан. **Үр дүн:** Судалгааны үр дүнд нийт оюутан залуусын 86,2% (n=872) нь согтууруулах ундаа хэрэглээ эрсдэл багатай, 12.8% (n=130) нь согтууруулах ундааны хэрэглээ эрсдэл өндөр байгаа нь тодорхойлогдов. Согтууруулах ундааны мэдлэгийн талаар үнэлсэн асуултанд нийт судалгаанд оролцогсдын 15,9% (n=160) нь муу, 50,6% нь (n=508) нь дунд, 33,1% (n=334) нь хангалттай мэдлэгтэй байна. Согтууруулах ундааны хэрэглээний өндөр эрсдэлтэй оролцогчид болон тэдгээрийн согтууруулах ундааны талаарх мэдлэгийн хооронд статистик ач холбогдол бүхий мэдлэгийн ялгаатай байдал ажиглагдаагүй. **Дүгнэлт:** Согтууруулах ундааны хэрэглээний өндөр эрсдэлтэй оролцогчид болон тэдгээрийн согтууруулах ундааны талаарх мэдлэгийн хооронд статистик ач холбогдол бүхий хамааралгүй байна. (P>0.05). Согтууруулах ундааны хандлага нь найзууд шаардсан учраас уудаг, үдэшлэг дээр хөгжилтэй байхад тусалдаг, нийгэмшихэд тусалдаг зэрэг шалтгаанууд нь согтууруулах ундааны хэрэглээтэй статистик ач холбогдол бүхий хамааралтай байна. (p<0.05)

Үндэслэл: Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын (ДЭМБ) 2021 онд гаргасан тайланд дурдсанаар 2019 онд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн архины хэрэглээ хамгийн өндөр байгаа нь Европын бүс, Америкийн бүс нутаг, Номхон далайн баруун хэсэгт байсан байна. Африкийн хөндлөн огтлолын судалгаагаар Өмнөд Африкт насанд хүрэгсдэд ногдох архины хэрэглээ дэлхийн бусад бүс нутгаас хамгийн өндөр байна.Түүнчлэн архины эрсдэлтэй хэв маяг нь 15-24 наснаас эхэлж насанд хүрсэн хойноо үргэлжилдэг байна. Халдварт бус

өвчин, осол гэмтлийн шалтгаант, эрсдэлт хүчин зүйл, тархалтын үндэсний судалгаанд монгол улсын 15-69 насны хүн амын 34.8% буюу 10 хүн тутмын 3 нь сүүлийн 1 сард архи согтууруулах ундаа хэрэглэсэн гэсэн стастистик гарсан байна. Согтууруулах ундаа болон тамхины хэрэглээний улмаас үүссэн дэлхий нийт төдийгүй монгол улсын хүн ам дундах халдварт бус өвчин, осол гэмтэл болон нас баралтын тэргүүлэх шалтгаанд тооцогдож байна. Согтууруулах ундааны мэдлэг, хандлага дутуугийн улмаас нэн ялангуяа залуу насныханд, согтууруулах ундаанд донтох, хэтрүүлэн хэрэглэх, цаашлаад бие махбодь болон сэтгэл санааны хохиролд учруулсаар байна. Тэр дундаа 15-24 насныхны оюутан залуучуудын дундах архи, тамхины хэрэглээний эрсдэлийн талаар мэдээлэх, согтууруулах ундаа хэрэглэх сэдлийг судлах зайлшгүй шаардлагатай. Стресс, сэтгэлийн түгшүүр, нийгмийн дарамт зэрэг нь ихэнх залуучуудад тулгардаг асуудлуудын нэгээхэн хэсэг нь юм.

Зорилго: 15-24 насны залуусын согтууруулах ундааны хэрэглээ, мэдлэг,хандлагыг судлах

Арга, аргачлал: Улаанбаатар хотын болон 4 бүсийг хамруулсан ЕБС, их дээд сургууль, коллеж болон МСҮТ-ийн 1002 оюутан залуусыг санамсаргүй түүврийн аргаар сонгож тэдгээрийн согтууруулах ундааны хэрэглээ, түүнтэй холбоотой мэдлэг, хандлагыг судлах тодорхойлох зорилготой уялдуулан судалгааг сургуульд суурилсан агшингийн загвараар хийж гүйцэтгэсэн. Асуумжыг согтууруулах ундааны хэрэглээний эмгэгийг тодорхойлох сорил (AUDIT-C) болон архины сэдлийн талаарх шинэчилсэн санал асуулга (DMQ-R) ашигласан. AUDIT-C (Архины хэрэглээний эмгэгийг тодорхойлох тест-хэрэглээ) нь согтууруулах ундааны хэрэглээг гурван богино асуултын тусламжтайгаар үнэлсэн. Эдгээр асуултын нийлбэр оноо нь эрүүл мэндэд учирч болох эрсдэлийг болон архи хэрэглэх зуршлийг харуулах юм. Асуулт бүрийн оноо нь таван онооны системээр 0-ээс 4 хүртэл байна.

Нэг хэсгийн нийлбэр онооны дээд тал нь 12 байна. Согтууруулах ундааны хандлагыг үнэлэхдээ архи уух сэдлийн асуулга, шинэчилсэн найруулга бүхий асуумж (DMQR) бүхий, хүмүүсийн согтууруулах ундаа хэрэглэх сэдлийг үүсгэж болох 20 шалтгааныг тусгасан. DMQ-R асуумж нь дотоод эерэг идэвхжүүлэлт (Идэвхжүүлэлт), гадаад эерэг идэвхжүүлэлт (нийгэмших), дотоод сөрөг идэвхжүүлэлт (даван туулах), гадаад сөрөг идэвхжүүлэлт (зөвшөөрөгдөх) гэсэн дөрвөн бүлэг сэдлийг тодорхойлсон. Согтууруулах ундааны мэдлэгийг үнэлэхдээ нийт 10 асуултаас 0-3 асуултанд зөв хариулсан тохиолдолд муу, 4-7 асуултанд зөв хариулсан тохиолдолд дунд, 8-10 асуултанд зөв хариулсан тохиолдолд мэдлэг сайтай гэж үнэлсэн. Судалгааны ажлын үр дүнгийн боловсруулалтыг IBM Statistics компанийн SPSS стастик үр дүнгийн боловсруулалтын 26.0 хувилбар дээр хийж гүйцэтгэв.

Судалгааны арга аргачлалыг АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2023 оны 01 сарын 20 ны өдрийн 2023/3-01 тоот хурлаар хэлэлцүүлж судалгаа эхлэх зөвшөөрлийг авсан.

Үр дүн: Судалгаанд 15-24 насны 1002 оюутан залуусыг санамсаргүй түүврийн аргаар хамруулсан ба хүйсийн хувьд эмэгтэй 57.6% (n=583), эрэгтэй 41.4% (n=419) хамрагдсан байна. Судалгаанд оролцогсдын ерөнхий мэдээллийг харуулав. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Судалгаанд оролцогсдын ерөнхий мэдээлэл

Үзүүлэлт	Тоо (n)	Хувь (%)
Нас		
15	115	11.5%
16	120	12%
17	150	15%
18	178	17.8%
19	116	11.6%
20	68	6.8%
21	74	7.4%
22	90	9%
23	59	5.9%
24	32	3.2%
Хүйс		
Эрэгтэй	419	41.4%
Эмэгтэй	583	57.6%
Сургууль		
Их дээд сургууль	414	41.3%
ЕБС	481	48%
МСҮТ	51	5.1%
Коллеж	29	2.9%
Сурдаггүй	27	2.7%

15-24 насны залуусын согтууруулах ундааны хэрэглээг тодорхойлсон үр дүн: Аудит С асуумжаар согтууруулах ундааны хэрэглээг тодорхойлсон асуултанд 86.2% (n=872) нь согтууруулах ундаа хэрэглээний эрсдэл багатай 12.8% (n=130) нь согтууруулах ундааны хэрэглээний эрсдэл өндөр гарсныг нас тус бүрээр харуулав. Согтууруулах ундааны хэрэглээ болон насны хооронд ач холбогдол бүхий хамааралтай байна. ($p<0.01$) Согтууруулах ундааны хэрэглээ болон хүйсний хооронд ач холбогдол бүхий хамааралгүй байна. ($P>0.05$) (Хүснэгт 2)

Хүснэгт 2. 15-24 насны заслуусын согтууруулах ундааны хэрэглээний эрсдэлт байдлыг нас тус бүрээр гаргасан байдал

Нас	Эрсдэл бага		Эрсдэл өндөр		Нийт	
	Тоо n	Хувь %	Тоо n	Хувь %	Тоо n	Хувь %
15.00	110	10.9%	5	0.4%	115	11.4
16.00	109	10.8%	11	1.09%	120	11.9%
17.00	142	14.1%	8	0.79%	150	14.9%
18.00	160	15.9%	18	1.7%	178	17.7%
19.00	100	9.9%	16	1.6%	116	11.5%
20.00	52	5.1%	16	1.6%	68	6.7%
21.00	61	6%	13	1.2%	74	7.3%
22.00	68	6.7%	22	2.1%	90	8.9%
23.00	47	4.6%	12	1.1%	59	5.8%
24.00	23	2.2%	9	0.8%	32	3.1%
Нийт	**872**	**86.2%**	**130**	**12.8%**	**1002**	

15-24 насны залуусын согтууруулах ундааны мэдлэгийг тодорхойлсон үр дүн: 15-24 насны залуусын согтууруулах ундааны мэдлэгийн талаар үнэлсэн асуултанд нийт судалгаанд оролцогсдын 15.9% (n=160) нь хангалтгүй, 50.6% нь (n=508) нь дунд, 33.1% (n=334) нь хангалттай мэдлэгтэй байсан. Хүйсийн хувьд эрэгтэйчүүдийн 7.3% хангалтгүй, 50.7% дунд, 31.7% хангалттай мэдлэгтэй байсан бол эмэгтэйчүүдийн 14.2% хангалтгүй, 51% дунд, 34.7% хангалттай мэдлэгтэй байна. Судалгаанд оролцогсдын согтууруулах ундааны талаарх мэдлэг болон насны хооронд статистик ач холбогдол бүхий хамааралтай байв. (P<0.01). Согтууруулах ундааны хэрэглээний өндөр эрсдэлтэй оролцогчид болон тэдгээрийн согтууруулах ундааны талаарх мэдлэгийн хооронд статистик ач холбогдол бүхий мэдлэгийн ялгаатай байдал ажиглагдаагүй.

15-24 насны залуусын согтууруулах ундааны хандлагыг тодорхойлсон үр дүн: Залуусын согтууруулах ундааны хандлага нь залуусыг нийгэмшихэд тусалдаг, гутарч шаналсан үед болон үдэшлэг дээр хөгжилтэй байхад тусалдаг зэрэг шалтгаанууд нь согтууруулах ундааны эрсдэлтэй хэрэглээтэй бүлэгт хамгийн олон давтамжтай тодорхойлогдсон. Залуусын согтууруулах ундааны хандлага нь тэдгээрийн согтууруулах ундааны мэдлэгтэй статистик ач холбогдолгүй байв. (p>0.05)

Хэлцэмж: Согтууруулах ундааны хэрэглээнээс улбаатай өвчлөл, эндэгдэлийн байдлыг тооцооллын болон тандалтын судалгаагаар Монгол улсын хэмжээнд судалсан зарим судалгаанууд байдгаас хамгийн цогц тооцооллыг Өвчний Ачаалал Дарамтын Олон Улсын Судалгаа олгож, бодит харьцуулалт хийх боломжийг олгодог. Хэвлэлийн тоймоос үзэхэд хамгийн сүүлийн загварчлал болох ӨОУ-ны 2019 оны загвараас үзэхэд 1990 онтой харьцуулахад согтууруулах ундааны шалтгаант өвчлөл, нас баралтын байдал нь ачаалал дарамт нь эрэгтэй хүйсэд тэргүүлэгч 2 дахь эрсдэлт хүчин зүйл болсон нь Монгол Улсад согтууруулах ундааны хөнөөлтэй хэрэглээ аюултай өндөр төвшинд байгааг анхааруулж байна. Согтууруулах ундааны хэрэглээг бууруулахад согтууруулах ундааны эрсдэлийг үнэлсэн, хэрэглээнд суурилсан анхан шатны эрүүл мэндийн байгууллагаар дамжин хүргэх архины товч интервенцүүдийг хэрэгжүүлэх нь олон улсын сайн туршлагад суурилсан үр дүнгүүд нотлож байна. оны Их сургуулийн оюутнуудын дундах архины хэрэглээний талаарх мэдлэг, дадлага АУДИТ-С асуумжаар үнэлсэн Messina, M. P., et al. (2021) нарын судалгаанд сурагчдын 53.3% нь архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэх эрсдэлтэй болохыг тогтоожээ.

Эрэгтэй сурагчид эмэгтэйчүүдээс илүү эрсдэл багатай байх магадлалтай (p<0.008) гарсан бол манай судалгаанд согтууруулах ундааны хэрэглээнд хүйсийн хувьд ач холбгдол бүхий хамаарал ажиглагдаагүй. (P>0.05) Согтууруулах ундааны хэрэглээг бууруулах, оюутан залуусын дунд мэдлэгийг дээшлүүлэхын тулд эрүүл мэндийн боловсролыг ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрт тусгаж, эрсдэл хор уршгийн талаар мэдлэгийг түгээх нь чухал байна.

Дүгнэлт: 15-24 насны залуусын согтууруулах ундааны мэдлэг судалгаанд нийт оролцогсдын 15.9% (n=160) нь хангалтгүй, 50.6% нь (n=508) нь дунд, 33.1% (n=334) нь хангалттай мэдлэгтэй байв. Залуусын согтууруулах ундааны хэрэглээ нь 86.2% (n=872) нь эрсдэл багатай 12.8% (n=130) эрсдэл өндөртэй байв.Залуусын согтууруулах ундааны хандлага нь тэдгээрийн согтууруулах ундааны мэдлэг болон хэрэглээтэы статистик ач холбогдолгүй байв. (p>0.05)

Ном зүй:

1. *Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын үндэсний IV судалгаа, STEPSS 2019*
2. *https://www.ncbi.nlm.nih.gov/pmc/articles/PMC7567026/#:~:text=GBD%202019%20provides%20the%20most,territories%20from%201990%20to%202019. (2023.04.25)*
3. *https://www.niaaa.nih.gov/alcohols-effects-health (2023.03.07)*
4. *https://www2.1212.mn (2022.12.15)*
5. *Messina, M. P., et al. (2021). "Knowledge and Practice towards Alcohol Consumption in a Sample of University Students." Int J Environ Res Public Health*
6. *Liskola, J. (2021). "The predictive capacity of AUDIT and AUDIT-C among adolescents in a one-year follow-up study." HELDA.*
7. *(2018). "Global, regional, and national comparative risk assessment of 84 behavioural, environmental and occupational, and metabolic risks or clusters of risks for 195 countries and territories, 1990-2017: a systematic analysis for the Global Burden of Disease Study 2017." Lancet 392(10159): 1923-1994.*
8. *Dashpuntsag, K., et al. (2021). "Awareness and Attitudes of Mongolian Adolescents and Youth toward Alcohol Consumption and Alcohol-related Harm." Addict Health 13(3): 185-193.*
9. *DiBello, A. M., et al. (2019). "Positive heavy drinking attitude mediates the association between college alcohol beliefs and alcohol-related outcomes." Addict Behav 88: 29-35.*
10. *Demaio, A. R., et al. (2013). "Exploring knowledge, attitudes, and practices related to alcohol in Mongolia: a national population-based survey." BMC Public Health 13: 178.*
11. *Armstrong, S. C. and B. Tsogtbaatar (2010). "The dual nature of alcohol use and abuse in Mongolia: reflections through policy." Asia Pac J Public Health 22(3 Suppl): 209s-215s.*

Results of the study of alcohol consumption, knowledge and attitudes of 15-24 year olds

Batchimeg B[1], Undram M[1], Enkh-Oyun Ts[2]

[1]Department of Family medicine, School of Medicine,MNUMS
[2]Department of Epidemiology and Biostatistics,School of Public Health, MNUMS
E-mail:Batchimegbayarsaikhan11@gmail.com, Tel: +976-99159717

Background: According to the World Health Organization (WHO) 2021 report, the highest rates of alcohol consumption among men and women in 2019 were in the European region, the American region, and the Western Pacific region. According to a cross-sectional study of Africa, South Africa has the highest per adult alcohol consumption of any region in the world, and risky drinking patterns begin between the ages of 15 and 24 and continue into adulthood.
Aim: To study of the alcohol consumption, knowledge and attitude of 15-24-year-olds
Materials and Methods: 1002 students of secondary schools, universities, colleges and vocational schools covering Ulaanbaatar city and 4 regions were randomly selected and the study was carried out using a school-based snapshot model. The research results were processed using IBM Statistics SPSS statistical results processing version 26.0.
Results: As a result of the research, it was determined that 86.2% (n=872) of all students have a low risk of alcohol consumption, and 12.8% (n=130) have a high risk of alcohol consumption. 15.9% (n=160) of the participants in the study had poor knowledge, 50.6% (n=508) had moderate knowledge, and 33.1% (n=334) had sufficient knowledge about alcohol. No statistically significant differences in knowledge were observed between participants at high risk of alcohol use and their knowledge of alcohol.
Conclusions: There was no statistically significant association between participants at high risk of alcohol use and their alcohol knowledge. ($P>0.05$). Attitudes toward alcohol include reasons such as drinking because friends insist, it helps to have fun at a party, and it helps to socialize. ($p<0.05$)

Keywords: Drinking habit, Standart drink, Risk behavior, Adolescent